

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан дараах үйлчилгээний хөлс, тэмдэгтийн хураамжийг төлнө.

25.1.5. ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон үйл ажиллагаанд дор дурдсан хэмжээгээр:

№	Үйлчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ /төгрөг/	
		Ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөл эзэмшигч	Ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигч
1	Тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүсч гаргасан өргөдлийг хянан үзэх	250 000	1 000 000
2	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай өргөдлийг хянан үзэх	1 500 000	7 000 000
3	Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийг хянан үзэх	1 000 000	2 000 000
4	Тусгай зөвшөөрлийг барьцаалах өргөдлийг хянан үзэх	1 000 000	2 000 000
5	Барьцааны гэрээний дагуу тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг хянан үзэх	1 000 000	2 000 000
6	Талбай буцааж хүлээлгэн өгөх өргөдлийг хянан үзэх	50 000	500 000
7	Хилийн маргааныг шийдвэрлүүлэх тухай өргөдлийг хянан үзэх	250 000	500 000
8	Үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг нөхөн олгох	200 000	250 000
9	Нэмэлт өргөдлийг хянан үзэх	200 000	1 000 000

35.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь доор дурдсан төлбөр төлнө:

35.6.1. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 200 төгрөг, хоёр дахь жилд 400 төгрөг, гурав дахь жилд 600 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 2000 төгрөг;

35.6.2. түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн 0-20 гектар тутамд 5000 төгрөг, 30 гектар хүртэл 8000 төгрөг, 50 гектар хүртэл 10000 төгрөг, 100 гектар хүртэл 15000 төгрөг, 200 гектараас дээш 20000 төгрөг.